



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны  
илэрхийлэл тогтоох тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2000 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийн 1 дэх хэсгийн 1.7 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу 2016, 2017, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эмэгтэй даатгуулагчдын хувьд тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 22 жил 6 сараар тогтоосугай.

2. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу тэтгэвэр бодоход баримтлахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын алба (Р.Отгонжаргал)-нд үүрэг болгосугай.

ДАРГА  С.ЧИНЗОРИГ

